

## ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

- 1. Өмнөх** хэлэлцүүлгээс хүн худалдаалах гэмт хэрэгтэй шууд холбоотой 8 зөвлөмж<sup>i</sup> өгснөөс зургаа нь эрх зүйн зохицуулалтад хамаарах, хоёр нь хохирогчдод үзүүлэх цогц үйлчилгээ, нөхөн төлбөр болон төсөв санхүүтэй холбоотой зөвлөмж байсан.
- 2.** “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хууль байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй, хүн худалдаалахтай тэмцэх төрийн үйл ажиллагаа нь “зөвхөн хурал, цуглаан хийх байдлаар хязгаарлагдаж” байна.<sup>ii</sup> Мөн ЕАБХАБ-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал хариуцсан тусгай төлөөлөгч Мадина Ярбуссинова<sup>iii</sup> дүгнэхдээ “Хүн худалдаалахтай тэмцэх” асуудлыг “Засгийн газрын оролцоотой хийхгүй бол үр дүн гарахгүй бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн асуудлыг “Хүн худалдаалахтай тэмцэх” болгох шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэсэн.<sup>iv</sup>
- 3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хангалттай хүний болон бусад нөөцийг бүрдүүлэх шаардлагатай байна.** Монгол Улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах “Дэд зөвлөл” нь 2013 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэд байгуулсан байдаг. Гэвч Дэд зөвлөл нь ХЗДХЯ-ны ГХУСЗ-ийн дэргэд албан бус бүтэцтэй, асуудлыг хариуцсан ганцхан мэргэжилтэн ажилладаг. ЦЕГ-ын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг нь 1 дарга, 4 мөрдөгчтэйгөөр зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ба хөдөө орон нутагт хүн худалдаалахтай тэмцэх тасаг, алба хаагч байхгүй байна. Хүн хүчний нөөц хангалтгүйгээс орон нутгаас хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж байсан тохиолдол жилд нийт илрүүлсэн тохиолдлын 4-5%-аас хэтрэхгүй байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр ажиллах боловсон хүчнийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Шүүх, прокурорын байгууллагад энэ чиглэлээр тусгай тасаг, бэлтгэгдсэн тусгай мэргэжилтнүүд ажилладаггүй. Төрийн нийгмийн халамж, хамгааллын байгууллагад ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж, бэлтгэгдсэн боловсон хүчин байхгүй.
- 4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бүх талуудыг чадавхжуулах шаардлагатай байна.** 2017 онд Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан.<sup>v</sup> Азийн сангийн АНУ-ын Төрийн департаментийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд<sup>vi</sup> шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын, ХХЕГ болон ГИХГ-ын нийт 709 албан хаагчдыг ХХГХ-ийг хохирогч төвтэй аргачлалаар хэрэг хянан шийдвэрлэх сургалтад хамруулсан байна. Тус төслийн хүрээнд энэ чиглэлээр үндэсний хэмжээнд нийт 34 сургагч багшийг бэлтгэсэн. Мөн тус төслийн хүрээнд ирээдүйд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох Дотоод хэргийн их сургуулийн нийт 2000 орчим сонсогчдод ХХГХ-ийн талаар ерөнхий мэдлэг, ойлголт өгөх, ХХГХ-ийг хохирогч төвтэй аргачлалаар хянан шийдвэрлэх талаар 8 удаагийн хагас өдрийн сургалт зохион байгуулсан. UNBOUND байгууллага хот, хөдөө орон нутгийн нийт 68 эрүүгийн мөрдөгч болон прокуроруудад сургалт зохион байгуулсан. Мөн Хүйсийн тэгш эрх төв нь ХЗДХЯ-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн хүрээнд 2018 онд 2 удаагийн сургалтаар 50<sup>vii</sup> өмгөөлөгчдөд хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, хохирогчдын онцлогийн талаарх мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулжээ. “Алба хаагчдыг мэргэшүүлэн сургах үйл ажиллагааны дийлэнх

хувийг олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа дуусахад төрийн байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэн сургах үйл ажиллагаа зогсох дүр зураг харагдаж байна. Төрийн болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын тогтмол сургалтын хөтөлбөрт ороогүй, төрөөс жил бүр энэ сургалтыг давтамжтай явуулахад зардал төсөвлөдөггүй. Иймээс алба хаагчдыг тогтмол сургах, сургалтын тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага байсаар л байна”.

- 5. Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, буруутай этгээдэд ял оногдуулах шаардлагатай.** Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хуулийн байгууллагын 2010-2016 оны статистик мэдээллээс үзэхэд хүн худалдаалах 8 гэмт хэрэгт 15 хүн, **6.** бие үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 36 гэмт хэрэгт 54 хүн шүүхээс ял шийтгүүлсэн<sup>viii</sup> байна.



Хүйсийн тэгш эрх төвд 2017 онд хандсан нийт 29 үйлчлүүлэгчдийн 20<sup>ix</sup> нь Цагдаагийн байгууллагад хандаж, хэргийг мөрдөн хянан шалгах ажиллагаа хийгдсэн ч шүүхээр хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх мэдээлэл байхгүй байна. Замын-Үүдийн хилийн боомтод UNBOUND ТББ-аас 2017 оны 6 сараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, 159 нь эрсдэл бүхий охидыг илрүүлж, 11 эмэгтэйг гэр бүлд нь аюулгүй буцааж ажилласан.

- 7.** Цагдаагийн байгууллагад 2017 онд Шинэчилсэн Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл буюу “Хүн худалдаалах” зүйлээр 12 хэргийг мөрдөн шалгаж, 7 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн талаар АНУ-ын Хүний наймааны төлөв байдлын 2018 оны тайланд дурдсан байна. Түүнчлэн Шинэчилсэн Эрүүгийн хуультай бүрэн танилцаж амжаагүй гэх шалтгаанаар Прокурорууд ял шийтгэл оногдуулах оновчтой бус, 26 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон ноцтой асуудал гаргасан ба эрх мэдэл бүхий төрийн алба хаагч, байгууллагууд хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн тоог бууруулаад зогсохгүй, энэ хугацаанд гэмт хэрэгтэнд ямар ч ял шийтгэл оногдуулаагүй талаарх 2018 оны тайланд дурдсан байна. Ийм ч учраас 2018 онд Хүний наймааны төлөв байдлын тайланд Монгол Улс нь 2-р шатлалын анхаарал татсан орны жагсаалтад орсон байсан бол 2019 онд 2-р шатлалд эргэн орсон.
- 8.** Эрүүгийн хуулийн 12.3 р зүйл буюу Бэлгийн мөлжлөг “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” бол бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Бэлгийн мөлжлөг (ЭХ-12.3.) хүн худалдаалах (ЭХ-13.1.) гэмт хэргээс зорчих эрхийг хязгаарлахгүй шинжээр ялгагдаж байгаа боловч

Палермогийн Протоколын 3-р зүйлийн хохирогч бэлгийн мөлжлөгт өртөж байгаагаар зөвшөөрсөн түүнчлэн МУ-ын Эрүүгийн хуулийн 13.1-д заасан хүн худалдаалах гэмт хэргийн тайлбарт дурдсан хохирогч зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй байх агуулгатай зөрчилдөж байна. Мөн хүн худалдаалах гэмт хэргийг бэлгийн мөлжлөг гэмт хэргээр зүйлчлэн шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлснээр хүн худалдаалах гэмт хэрэг зүйлчлэл өөрчлөгдөн, шийдвэрлэгдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Мөн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор насанд хүрээгүй, бага насны хүүхдийг албадан оруулж үйлдсэн тохиолдолд зүйлчлэлийг хүндрүүлэн ял оногдуулахаар заасан нь Палермогийн протоколын 3-р зүйл болон Эрүүгийн хуулийн 13.1.-д заасан хүн худалдаалах гэмт хэргийн тайлбартай зөрчилдсөн<sup>x</sup> байна. Энд зөвхөн бэлгийн мөлжлөгийн асуудлыг тусгасан ба хөдөлмөр мөлжлөгийн асуудлыг цаашид гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ шаардлага их байна. Тухайлбал, хилээр гарч буй жирэмсэн эмэгтэйчүүдэд хяналт тавих, хөдөлмөр мөлжлөгийн хэргүүд зэрэг асуудалд анхаарал хандуулах цаг болсон. .

**9. Хүүхдийг худалдаалах бүх хэлбэрийг эрүүгийн хэрэгт тооцох:** Шүүхээс өнөөдрийг хүртэл бэлгийн мөлжлөгөөс өөр төрлийн ХХГХ-т ял шийтгэл оногдуулаагүй байна. Шинэчилсэн Эрүүгийн хуульд **Хүүхэд худалдах** /хуулийн 16.6./ гэдэгт төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан нь энэ хуулийн 13.1-р зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан. Одоогоор хуулийн хэрэглээ, үр нөлөөний талаар хийгдсэн судалгаа байхгүй байна. Цаашид судлах шаардлагатай байна. Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн асуудлаас гадна албадан хөдөлмөр, хөдөлмөр мөлжлөг, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр гэсэн ойлголт өнөөг хүртэл анхаарал татсан асуудал нэг хэвээр л байна. Тухайлбал, хүүхдийг албан бус хэвшилд хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, хурдан морь унуулах, уран нугараачаар ажиллуулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, мал маллуулах, гуйлга гуйлгах зэрэг хөдөлмөр мөлжлөгийн хэргүүд бүртгэгдэж байгаа хэдий ч эцэслэн шийдвэрлэгдэхгүй, хүн худалдаалах гэмт хэргийн нэг төрөл гэдгээр зүйлчлэн ял шийтгэл оногдуулахгүй байна.

**10. Хохирогчид үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх, хохирогч, гэрчид эрх зүйн туслалцаа үзүүлэх, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх төсвийг бүрдүүлэх:** Хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх ажлын дийлэнх хувийг өнөөг хүртэл Төрийн бус байгууллагууд Олон улсын байгууллага, донорын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдын аюулгүй байдлыг хангах зорилго бүхий хоёр төрлийн хамгаалах байрыг Хүйсийн тэгш эрх төв нь 2010 оноос эхлэн өнөөг хүртэл ажиллуулсан ба Засгийн газраас ямар нэгэн санхүүгийн дэмжлэгийг сүүлийн 5 жилийн хугацаанд аваагүй. 2019 онд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нэг жилийн хугацаатай 20 000 000<sup>xi</sup> (7,540 US\$) төгрөгийн санхүүгийн дэмжлэг авах хамгаалах байрны урсгал зардал ороогүй, зөвхөн 15 хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах юм. Өнөөг хүртэл хохирогч хамгааллын асуудлаар ажиллах төрийн, бүтэц механизм бий болоогүй, бүх байгууллагууд салангид үйл ажиллагаа тогтворжоогүй, санхүүгийн эх

үүсвэргүй, төрийн бус байгууллага донор байгууллагуудын дэмжлэгээр үзүүлж байна.

**11. Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай:** Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид нөхөн төлбөр, олговор олгох асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй хэвээр байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15-р зүйлд хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй гэсэн заалттай хэдий ч Эрүүгийн болон Иргэний хуульд өөр хоорондоо нийцэхгүй байдал нь энэхүү хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэх боломжийг хааж байна. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эрүүгийн, иргэний хэрэгт хохирогч нөхөн төлбөр гаргуулсан тохиолдол байхгүй, шүүхийн практикт сэтгэл санааны хохирлыг тооцохгүй хэвээр л байна. 2016 онд ХХГХ-ийн хавтаст хэргүүдэд хийсэн дүн шинжилгээгээр хохирогч өөрт учирсан бодит хохирлоо нэхэмжилсэн ч нотлох баримт байхгүй, хууль бусаар орсон орлогыг тооцон олгохгүй гэх шалтгаанаар ердөө шүүхээс нэхэмжлэлийн 6%-ийг барагдуулахаар шийдвэрлэсэн<sup>xii</sup>. Мөн 2015 оны Шинэчилсэн Эрүүгийн хуулийг батлахдаа Засгийн газрын тусгай сан<sup>xiii</sup>гийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Гэтэл 2015 оны Шинэчилсэн Эрүүгийн хуулийн 13.1 буюу хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод нөхөн олговор олгох асуудлыг хасаж, хүчингүй болгосон байгаа нь хохирогч хамгаалал, тэр дундаа нөхөн олговор олгох асуудалд ухралт гарсан гэж үзэж байна.

### **Зөвлөмж**

1. 2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх хуулийн хэрэгжилтэд нарийвчилсан үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах, сайжруулах
2. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг өргөтгөж, байнгын үйл ажиллагаатай бүтцийг бий болгох, салбар дундын зохицуулалтыг хангах замаар үйл ажиллагааг эрчимжүүлэх, тогтмолжуулах, түүнчлэн хүн худалдаалахын төрлүүдэд чиглэсэн ажлын хэсгүүдийг байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудыг бүрэлдэхүүндээ оруулах
3. Жил бүр хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаатай холбогдуулан хийсэн ажлын тайланг гаргаж хэлэлцүүлэх, үнэлэлт, дүгнэлт өгч, дараа жилийн төлөвлөгөөндөө тусгаж ажиллаж байх
4. Хүн худалдаалах гэмт хэргийн шинэ төрөл, хандлагад тогтмол судалгаа шинжилгээ хийж, хүн худалдаалах хэргийн бусад төрлийн гэмт хэргүүдийг таньж мэдэн ял шийтгэл оногдуулж байх Тухайлбал, хөдөлмөр мөлжлөг, хилээр гарч буй жирэмсэн эмэгтэйчүүдэд хяналт тавих, уул уурхай дагасан бэлгийн мөлжлөг гэх мэт.
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр алба хаагчдын хүний нөөцийг нэмэгдүүлэх ялангуяа Цагдаагийн байгууллагад хэргийн хянан шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч мөрдөгч нарыг нэмэгдүүлэх, тогтмол мэргэшүүлэх, бусад улсын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллах
6. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажилтнуудыг тухайн байгууллагын сургалтын төвүүдээр дамжуулан тогтмол мэргэшүүлэн сургах сургалтын тогтолцоог бий болгох, үйл ажиллагааг тогтмолжуулах, үр дүнд байнга хяналт тавьж байх

7. Хохирогчид нөхөн олговор олгох асуудлаар МУ-д хэрэгжиж буй хуулиудад үнэлгээ хийж, цоорхой болон давхардлыг илрүүлж, хохирогчид учирсан нөхөн төлбөр олгож байх нөхцөлийг эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид оновчтой зааж, тусгах, хэрэгжүүлэх
8. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг цогц, тогтвортой үзүүлэх боломжийг бүрдүүлэх
9. Хохирогчдод үзүүлэх шууд туслалцаа, нөхөн сэргээх үйлчилгээнд Засгийн газраас тусгайлсан зардлыг жил бүр улсын төсөвт суулгах
10. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд Хүн худалдаалах /13.1/ зүйл заалтыг тусгах <sup>xivxv</sup>

---

<sup>i</sup> Зөвлөмжийн 5.116-5.123 хүртэл

<sup>ii</sup> 2018 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтарсан “Иргэний оролцоо 2” төслийн хүрээнд “МУ-ын хуулиуд дахь иргэний оролцооны талаарх зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ судалгааны үр дүнгийн тайлан”<sup>ii</sup>-д

<sup>iii</sup> Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Д.Нямгэрэлийн 2018 оны 7/1726 тоот албан бичгээс хэсэгчлэн тусгав.

<sup>iv</sup> Монгол Улсад 2017 оны 10-р сарын 4-6-ны өдрүүдэд

<sup>v</sup> Засгийн газрын 2017 оны 148-р

тогтоол/<https://www.legalinfo.mn/law/details/12751?lawid=12751>

<sup>vi</sup> Азийн сангийн Монгол улс дахь төлөөлөгчийн газар, 2019 оны 9 дүгээр сарын 9

<sup>vii</sup> Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангаас дурдав.

<sup>viii</sup> ЗГ-ын 2017 оны 148-р тогтоолын хавсралт, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нийтлэг үндэслэл

<sup>ix</sup> 2018 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай

тайлан/<https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

<sup>x</sup> ХЗДХЯ, Азийн сангийн захиалгаар ХТЭТ-ийн хийсэн “ХХГХ-тэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой МУ-ын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх” судалгааны тайлан, 2017 он, хуудас 29

<sup>xi</sup> <https://www.tender.gov.mn/mn/result/detail/1554394ажиллаж 900>

<sup>xii</sup> Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг: ХХГХ-ийн жишээн дээр хавтаст хэргүүдэд хийсэн дүн шинжилгээ, 2016 он, ННФ, ХТЭТ

<sup>xiii</sup> Төрийн мэдээлэл, 2006 он, Дугаар 27